

Урвалт ба Сэргээлт шаардлагатай гэдгийг ойлгох

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Судрын дараах хэсгүүдийг болон ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны мэдэгдлийг судалсныхаа дараа доорх асуултуудад хариул.

1. 1 Нифай 13:24–28: Нифай Библи дээрх чухал үнэнүүдэд юу тохиох талаар үзэгдэл харжээ.
2. Амос 8:11–12: Амос удахгүй тохиох сүнслэг өлсгөлөнгийн талаар бошигложээ.
3. Үйлс 20:29–30: Паул Аврагчийн Сүмийн гишүүд сайн мэдээнээс холдох болно гэдгийг сануулжээ.
4. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ийн заасан.



“Амьд Бурхан маань хайрын Бурхан билээ! Тэр Өөрийн хүүхдүүдийг Түүнийг болон Түүний илгээсэн Есүс Христийг мэдээсэй хэмээн хүсдэг! Мөн Тэр Өөрийн хүүхдүүдийг үхэшгүй байдал болон мөнх амьдралыг олж аваасай гэж хүсдэг билээ!

Энэхүү алдар суут зорилгын төлөө номлогчид Сэргээлтийн тухай заадаг. Тэд 2000 орчим жилийн тэртээ, Их Эзэн Өөрийн сүмийг зохион байгуулсан гэдгийг мэддэг. Түүний цовдлолт болон Түүний төлөөлөгчид нас барсны дараа, хүмүүс сүм болон сургаалыг өөрчилжээ. Тэгээд олон үеийн турш сүнслийн харанхуй байдалд байсны дараа эртний бошиглогчдын зөгнөснөөр Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ сүм, сургаалыг, санваарын эрх мэдлийг дахин сэргээсэн юм. Сэргээлтийн улмаас аврал болон өргөмжлөлийн талаарх мэдлэг болон ёслолууд бүх хүнд дахин боломжтой болсон юм. Эцэст нь өргөмжлөл нь бидний хүн нэг бүрд Бурхан болон Есүс Христийн оршихуйд гэр бүлтэйгээ үүрд хамтдаа орших боломжийг олгодог билээ!” (Рассэлл М.Нэлсон, “Давалгаанд нэгдэгтүн” *Ensign*, May 2013, 46 эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 55–56)

- Та эдгээр судрын хэсгээс болон ерөнхийлөгч Нэлсоны мэдэгдлээс Их урвалтын талаар юу олж мэдсэн бэ?
- Та эдгээр сургаалаар дамжуулан Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын талаар юу олж мэдсэн бэ?
- Олж мэдсэн зүйл дээрээ тулгуурлавал Сэргээлт яагаад шаардлагатай байсан бэ?

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ